

«МАТАР» СЭТГҮҮЛИЙН ХОШИН ШОГ
НИЙТЛЭЛИЙН ОНЦЛОГ, ҮНДСЭН СЭДВҮҮД

Н.Мөнхзориг*

* "Идэр" дээд сургуулийн багш, магистр, докторант

Түлхүүр үг: хошин шог нийтлэл, илчлэн шүүмжилсэн нийтлэл, «Хүмүүжил жигшил» сэтгүүл, «Матар» сэтгүүл.

1934

онд намын IX их хурлаас феодалын нийгмийн үлдэгдэлтэй хийх тэмцлийг хүчтэй болгохыг заасны дагуу 1935 оны 11-р сард анхны дугаар нь хэвлэгдэн гарсан, нийгэм улс төрийн шог сэтгүүл «Хүмүүжил жигшил»-ээр Монголын хошин шог нийтлэл эхэлдэг. Хошин шог нийтлэл дагнан бичих болсон энэ сэтгүүл нь манай хошин шог нийтлэлтэй тогтмол хэвлэлийн эхлэл юм.

1942 оны 1-р сард анхны дугаар нь гарсан «Матар» сэтгүүл бол Монголын хошин шог нийтлэлийн хөгжилд чухал хувь нэмэр оруулсан түүхэн тогтмол хэвлэл мөн. Ер нь 1913-1920, 1920-1940-өөд оны үеийн манай тогтмол хэвлэлүүдийн нийтлэл нь ерөнхийдөө илчлэн шүүмжилсэн шинжтэй боловч

яг хошин шог нийтлэлийн төрөл зүйл тун бага юм. Хошин шог нийтлэл жинхэнэ утгаараа «Хүмүүжил жигшил» сэтгүүлээр эхэлж, «Матар» сэтгүүлээр үргэлжлэн хөгжжээ. Дашрамд хэлэхэд «Хүмүүжил жигшил» сэтгүүл нь 1942-1960 он «Матар» нэрээр гарч байжээ гэж ойлгож болохоор байна. Харин 1961 оны 1-р сараас 1965 оны 12-р сар хүртэл эргээд «Хүмүүжил жигшил» нэрээр гарч байжээ. «Матар», «Хүмүүжил жигшил» хоёр аль аль нь сар тутмын сэтгүүл байв. «Матар» сэтгүүл 1942-1945 он хүртэл монгол бичгээр, 1946 оноос хойш кирилл үсгээр гарч байв.

«Матар» сэтгүүлийн нийтлэлийн гол төрөл зүйл нь шог нийтлэл, шог мэдээ, шог шүлэг, жижиг шог, шог зураг байсан юм. Мөн тэр үеийн идэвхтэн бичигч, зохиолчдын бичсэн ёгт үлгэрүүд, орчуулгын хошин шог бүтээлүүд, жижиг явган шогууд, шүүмжлэлт шог хошин нийтлэлүүд элбэг байна.

«Матар» сэтгүүлийн хэл найруулга, үг хэллэг нь тэр үеийн монгол хэлний

үг хэллэгтэй байна. Үүнийг ОЦМХ-ний хэл зүйн дүрэм, хэл найруулгатай харьцуулах нь мэдээж учир дутагдалтай.

«Матар» сэтгүүлийн эхний дугааруудад хошин шог гэж нэрлэхээргүй энгийн нийтлэлүүд ч олон байна. Тухайлбал: тус сэтгүүлийн анхны дугаарт цаг үеэ тусгасан хошин шог шүүмжлэлт өгүүл-

лүүдээс гадна хошин гэхээргүй энгийн нийтлэлүүд ч цөөнгүй юм. Тус дугаарт «Шинэ жилийн наран», «Бидүлий хүн биш та минь», «Баясгалант наадам» зэрэг материал нийтлэгдсэний «Шинэ жилийн наран», «Баясгалант наадам» зэрэг нь

энгийн нийтлэл байна. Дугаарын «Шинэ жилийн наран» хэмээх нийтлэлд:

«... Өрнийн олон уулнуудад үдийн наран буухад, сайхан улаан тугт саруул туяа бадармуй. Дэлхий дахиныг гийгүүлсэн дэлгэр тэр туяа бол баясгалант шинэ жилийн баярын мэндийг хүргэж... агуу ялалтыг авчрав. Эрийн цээнд хүрч, буцах жилийг утгаж, идэр нас нь гүйцэж, идэр жилийг угтсан, хүчит Монгол орны хөвгүүд олон баатрууд баярт үгийн дээжийг байлдагчуудад зориулна... ТҮҮХТ СССР улс танд ачийг эрчимт

тэмцлээр хариулах шинэ он гарав... Хосгүй гайхамшигт хоёр нарны дор халуун зоригоо гангалж, хамаг хөдөлмөрөө бүтээнэ. Нэгэн нар нь бол шинэ жилийн гэгээн наран, нөгөө нар нь бол шинэ Монголын Чойбалсан наран...»¹ гэх зэргээр бичсэн байх жишээтэй.

«Баясгалант наадам» ч үүний адил

бичлэгтэй юм. Энэ хоёр өгүүлэл хошин шог нийтлэл биш байна. Гэхдээ ийм энгийн нийтлэлүүд зөвхөн 1942, 1943 оны дугааруудад цөөхөн тооны үзэгдэж байсныг хэлэх нь зүйтэй. Харин 1943 оны сүүл, 1944 оны эхний дугааруудаас эхлэн «Матар» сэтгүүлийн

«

1942 оны 1-р сард анхны дугаар нь гарсан «Матар» сэтгүүл бол Монголын хошин шог нийтлэлийн хөгжилд чухал хувь нэмэр оруулсан түүхэн тогтмол хэвлэл мөн. «Матар» сэтгүүлийн нийтлэлийн гол төрөл зүйл нь шог нийтлэл, шог шүлэг, жижиг шог, шог зураг байсан юм. Мөн идэвхтэн бичигч, зохиолчдын бичсэн ёгт үлгэрүүд, жижиг явган шогууд, шүүмжлэлт шог хошин нийтлэлүүд элбэг байсан байна.

»

хошин шог нийтлэл нэлээд зүгширч төлөвшиж эхэлсэн нь ажиглагддаг.

Сэтгүүлийн эхний жилүүдэд гарч байсан дугааруудад Да-гийн су юм уу, Да-гийн сурвалжлага, Го-гийн сурвалжлага, У-гийн Су гэх мэт нэрийг эс тооцвол бараг зохиогчийн нэрийг тавьдаггүй байв. Гэхдээ цөөхөн тооны тогтмол бичигчид нь нэрээрээ бүтээлээ гаргадаг байлаа. Харин 1940-өөд оны сүүлчээс эхлэн зохиогч бүр нэрээрээ тавьдаг болжээ.

Сэтгүүлийн хошин шог нийтлэлийн нэг онцлог нь өгүүлэх гэж байгаа

зүйлийнхээ тухай эхэлж дурьдаад, дараагаар нь тодорхой баримт, нэр устай, аймаг, сум, харъяалалтай уг асуудлаа бичдэг байсан явдал мөн.

«Матар» сэтгүүлийн эхний дугааруудын бас нэг онцлог гэвэл, ихэнх материал нь идэвхтэн бичигчдийн захидлаар бүтдэг байв. Идэвхтэн бичигчдийн захидал нь сэтгүүлийн нийтлэлийн нэлээд идэвхтэй хэсгийг бүрдүүлж байжээ.

«Матар» сэтгүүл 1942 оны 1 дүгээр сараас 1960 оныг дуустал энэ нэрээрээ гарсан байна. Харин 1961 оны 1 дүгээр сараас эхлэн тус сэтгүүлийн үргэлжлэл хэлбэрээр «Хүмүүжил жигшил» сэтгүүл гарч эхэлжээ.

«Матар» сэтгүүлийн нийтлэлийн агуулгыг илэрхийлсэн тэр үеийн зураг урлалын газраас зурсан, шог зургууд нэлээд анхаарал татдаг. Тус сэтгүүл дэх зурган нийтлэлийн далд санаатай шүүмжлэлийн утга нь гүнзгий юм. «Матар» сэтгүүлийн тайлбартай шог зураг нь ихэнхдээ хөдөлмөрийн хүний дутагдал, олон нийтийн ажлыг цалгардуулж байгааг шүүмжилсэн сэдэвтэй байна. Энэ ганцхан сэдвийг хөнддөг байсан нь дутагдалтай боловч уг сэтгүүлийн шог зурагт хоёр давуу тал ажиглагддаг. Нэгдүгээрт, тухайн нийгмийн хөгжилд тодорхой хэмжээгээр саад болох зүйлийг шүүмжилж байв. Хоёрдугаарт, тэр шүүмжлэлд өртөгч нь тодорхой нэр ус, аймаг сумын харъяалалтай албан тушаалтан байдаг. Тус

сэтгүүлийн нийтлэлүүдийн агуулгыг илэрхийлсэн зургууд нь тухайн үеийн зураг урлалын газраас бүтээгддэг байсан ба энэ зурмал зургууд «Матар» сэтгүүлийн хошин шог нийтлэлийн агуулгыг бүрэн илэрхийлж чадаж байснаараа давуу талтай юм.

«Матар» сэтгүүлийн нийтлэл нь ерөнхийдөө дараах сэдвүүдээр бичигдэж байв. Тухайлбаас хариуцсан үүрэгт ажилдаа эзэн бололгүй, унтахаас өөрийг мэддэггүй, залхуу хойрго, хоёр нарны хооронд унтсаар хамаг ажлаа алддаг албан тушаалтан юм уу, хөдөлмөрийн шинэ хүн, шинэ цаг үед саад болж байгаа дутагдлыг, мөн Гитлер тэргүүтэй харгис хэрцгий фашизмын дэглэм, фашистуудыг илт үзэн ядаж шүүмжилсэн шинжтэй нийтлэлүүд элбэг байгаа нь ажиглагдаж байна. Мөн ажилдаа хариуцлагагүй албан тушаалтан, ажилтан, ардын шинэ сургуулийн багш, сурагчдын замбараагүй хичээл, багш, сурагчдын анги танхим, ширээ сандал зэрэг эд материалд хэрхэн хайр гамгүй, сурлага хөдөлмөрт яаж хайхрамжгүй хандаж байгаа, сонины уншлага таслагчид, архи дарсанд толгойгоо мэдүүлж албан ажил цалгардуулагчид, муу малчид, бохир заваан байдал, мэргэшсэн хульгайчдыг шоглон шүүмжилсэн нийтлэл олонтаа тохиолдоно. Тухайлбал: «Матар» сэтгүүлийн 1942 оны 1-р сард хэвлэгдэн гарсан анхны дугаарт

нийтлэгдсэн «Бид дүлий хүн шүү та минь» хэмээх өгүүлэлд Гар үйлдвэрийн эвлэлийн дарга Нансрай

«...— Би хачин их унтдаг хүн шүү дээ. Та нар дуулж бай л даа. Хамар ихтийн ус их, хацар ихтийн нударга их гэгчээр хамар дотроо нусаа хурхируулаад харах нүдээ нуухаар шавж бүрхүүлээд гашилсан шүлстэй үмхий амаараа хааяа нэг эвшээлгээд хөрз болсон хэлээрээ уруул амаа долоогоод л хөөрхий чинь тэгээд л холцортлоо жийж хонгинолоо хурхираад, дүнзэн модны тайрдас шиг, дүлий зангийн годил шиг зүгээр л нүхэндээ ичсэн өвлийн тарвага шиг л унтдаг байх юм даа... Шургаж унтсаар байгаад чих минь үд хүртэл дүлий байна даа...»² гэх зэргээр гар үйлдвэрийн эвлэлийн дарга Нансрайн үдийн 11 цаг хүртэл, ичээндээ орсон тарвага шиг унтаж байгаад, арай чамай гэлдэрсээр ажилдаа очтол, 16 цаг болж эргээд харих болдог, дэндүү урагшгүй, унтамхай, хойрго байдлыг шоглон шүүмжилсэн бол, 1942 оны 6-р сард хэвлэгдэн гарсан 5-6 дахь дугаарт нийтлэгдсэн «...Тариалангийн төлөвлөгөөг ийнхүү биелүүлжээ» нийтлэлд Төв аймгийн Батсүмбэр сумын дунд сургуулийн захирал Мандалбаяр, хичээлийн эрхлэгч Санжав нар газар тариалангийн ажилд хэрхэн хойрго хандан залхуурч, сургуульдаа тарих ёстой 50 га газраас дөнгөж 10 га тарьчихаад хэнэгч үгүй «энэ жилдээ дажгүй

ногоотой...»³ гэж суугаа дэндүү арчаагүй байдлыг илчлэн шүүмжилсэн байна.

Мөн «Матар» сэтгүүлийн 1943 оны №3-т нийтлэгдсэн «Малын эмчийн намтар» хэмээх өгүүлэлд Дундговь аймгийн Луус сумын малын бага эмч Лхамсүрэн хайран мал сүрэгт халдварт өвчин хатуу тархаж байхад ажиг ч үгүй лаглайн суучихаад «...малчин ард олноос малын эмчдээ хэлэхэд, шинэ үүсгэсэн өвчин биш сэтгэл зовсоны хэрэггүй гэнэ. Хараал зүхэл болж хавьтсан ойртсондоо хэлэх нь хамаг өвчнийг эмчилдэг хар тос байдаг юм. Пошкод (торх) байх тосноос бушуухан хайж аваад, буцах хэрэгтэй гэж буруу харад хэвтдэг...»⁴ арчаагүй залхуу, хариуцлагагүй байдлыг илчлэн шоглосон байхад, мөн дугаарын «Хөдөлмөрт дургүйчүүдийн уршиг» нийтлэлд төмөр замын ажилчдын сахилга бат нь задгай болж, хот орныг нүүрсээр хангахын оронд хоорондоо хэрэлдэх, ажлаа таслах явдлаас шалтгаалж нүүрсээр зарим газрыг гачигдуулж ихээхэн хохирол учруулж байгаагийн дээр ажилчид нь ажлын цагийг хий дэмий үрдэг төдийгүй, төмөр замын захиргааны удирдлага нь сахилга батаа алдсан ажилчдынхаа дотор хамт хутгалдсаныг тодорхой жишээ баримтаар «...32 онд 9 хүн ажлаас оргон зайлсан ба 72 хүн бүхий энэ газрын ажилчдын зууны 50% нь 815 цаг 50 мин ажлыг тасалдуулжээ.

Иймэрхүү явдал 33 ондоо улиран шилжиж иржээ. Жишээ нь: 1 сарын 25 хүртэл 40 цаг тасалдуулсан байна»⁵ гэгчлэн шүүмжилжээ.

Түүгээр ч зогсохгүй дутагдал гэж юу болохыг учирлаж тайлбарласан, шоглож шүүмжилсэн нийтлэл байгаа нь тус сэтгүүл илчлэн шүүмжилсэн хошин шог нийтлэлийг тууштай хэвлэж байсныг батална. Жишээлбэл: «Матар» сэтгүүлийн 1942 оны 4-р сард хэвлэгдэн гарсан 4 дэх дугаарт Ц.Цэдэнжавын хэвлүүлсэн «Сануулга» хэмээх хошин шог өгүүлэлд дутагдал гэдэг нүхтэй адил, дутагдалтай хүн нүхэнд унахтай адил хэмээн харьцуулаад, дутагдалтай хүн тэр нүхэнд унадаг болохыг сануулаад, унагаж гэмтээх нүх болсон дутагдлыг алганд орсон өргөс шиг ч санахгүй осолдож төөрөх шөнө болсон эндэгдлийг шүдний завсар шигдсэн мах шиг ч бодохгүй, залхуу занг ах шиг хүндэтгэж, хойрго байдлыг дүү шигээ хайрлагчдын шоглон шүүмжилжээ.

Өгүүлийн ач холбогдол нь дутагдал, эндэгдэл, залхуу хойрго байдлыг тууштай шүүмжилсэнд оршино. Ингэхдээ жишээлж авсан хоршоо даргын ямаа самнаж буй урагшгүй байдлаар олон дутагдлыг төлөөлүүлсний дээр өгүүлийн эцэст «...хэн гишүүн, хэн дарга, хэн эрхлэгч цөм бүгдээр өөрийн сум хэдэн ямаа, хоньтойг хэдэн сам хэрэгтэйг хүртэл, гэр доторх хогшил

шиг бүртгэж, алган дээрх будаа шиг тоолж, алгасалгүй санаж алдалгүй мэдэх нь чухал...»⁶ болохыг сануулжээ.

«Матар» сэтгүүлийн нийтлэлүүдэд тусч байсан өөр нэг чухал сэдэв бол фашизмын харгис дэглэм, фашизмыг илт үзэн ядаж шүүмжилж байсан явдал мөн. Тухайлбал: 1943 оны 3 дахь дугаарт нийтлэгдсэн «Нүдний булай» өгүүлэлд Германы дээрэмчид анх Оростой дайн хийвэл олз омог ихтэй гэж шунхайран довтолж, бяр чадалгүй эмэгтэйчүүдийг хүчирхийлэн доромжилж, багачуудыг жадалж, насанд дарагдсан эмэгтэйчүүдийг шатаан түймэрдэж, өвгөдийг буудан хядаад, соёл боловсрол ба уран сайхны газруудыг эвдэн бусниулж дээрэмдээд, сүрхий их зантай сагсуурч явснаа өмнөө барьдаг 6-р армия Сталинградын дэргэд Оросын улаан цэрэгт бут ниргүүлэн «...отрядаа орхиж, тал намаг дундуур нус нулимсаа цувруулаад, цус нөжөө гоожуулан...»⁷ ухаан жолоогүй зугтаж байгааг шоглон шүүмжилсэн байдаг.

«Матар» сэтгүүлийн нийтлэлүүдийн бас нэг гол сэдэв бол ажилдаа хариуцлагагүй албан тушаалтан, ажилтан байв. Жишээлбэл: 1942 оны 6-р сард хэвлэгдсэн 5-6 дахь дугаарт нийтлэгдсэн «Бага эмч Бадарчид зориулав» нийтлэлд малын бага эмч Бадарч мал баазад малчдын малыг тусгай актаар (хуурамч акт) авдаг төдийгүй, тэр малынхаа ноос үсийг ч авалгүй

«...Улаанбаатарын хүн болох учраас угаас сураагүй юм даа. Одоо ямаа самнаж ч мэдэхгүй, үхэр хөөвөрлөж ч мэдэхгүй...» хэмээн «...сургууль соёлд суралцан төгсгөж, үнэмлэх дэвтрээ өвөртөлсөн малын өвчнийг эмнэж эдгээдэд, энгийн албан тушаалыг хүлээсэн, 22 нас хүрсэн, хөрслөг бор царайтай Бадарч...»⁸ эмч ичих ч үгүй хэлж байгааг илчлэн шоглосон бол 1944

оны 3 дахь дугаарт нийтлэгдсэн «Будлиантай дарга» өгүүлэлд Төв аймгийн Угтаал Цайдам сумын 10-р багийн дарга Лувсандамбын харьяат ардынхаа малыг биечлэн тоолохдоо нэг ч осолдолгүй тоолсон

боловч тоо нь огт тохирохгүй зарим айлын нэг тэмээ гурав болоод, 10 үхэр 20 болоод байх эс бөгөөс ард Гойгармаа, Бямба нарын 200 гаруй мал орхигдоод байгаа зэрэг нь нутгийн ардуудын дунд «...Лувсандамба тэмээг тоолохын оронд тэмээн дээр гозойж байдаг хоёр бөх, нэг толгойг гурав гэж тоолсон бололтой. Үхрийг тоолохын оронд түүний эврийг тоолсон байж мэднэ. Чингээд Лувсандамба ямагт гозойж байсан юмыг тоолоод, хэвтэж байсан үхэр, хонь зэргийг тоололгүй орхисон юм болов уу?...»⁹

гэх зэргээр инээдэм болон яригдаж буйгаар нөхөр даргын будлиу, мунгинуу явдлыг элэглэж, ганц мал тоолох биш, мал өсгөх, мал гээгдүүлэх, онд оруулах, чоно алах зэрэг ажилд мөн энэчлэн ханддагийг давхар шүүмжилсэн байна.

Сэтгүүлийн нийтлэлийн өөр нэг гол сэдэв бол ардын шинэ сургуулийн

багш сурагчдын замбараагүй байдал, анги танхим, ширээ сандал зэрэг эд материалдаа хайр гамгүй, сурлага хөдөлмөртөө хайхрамжгүй хандаж байгаа явдал байсан юм. Наад захын жишээ дурдахад «Матар» сэтгүүлийн 1943 оны 1 дэх дугаарт нийтлэгдсэн

«**«Матар» сэтгүүлийн нийтлэлийн өөр нэг гол сэдэв бол ардын шинэ сургуулийн багш сурагчдын замбараагүй байдал, анги танхим, ширээ сандал зэрэг эд материалдаа хайр гамгүй, сурлага хөдөлмөртөө хайхрамжгүй хандаж байгаа явдал байсан юм. Үүний нэг тод жишээ бол 1943 оны 1 дэх дугаарт нийтлэгдсэн «Өөд нь тат» өгүүлэл билээ.**

«Өөд нь тат» өгүүлэлд Булган аймгийн төвийн шинэ үсгийн бүлгэмийн багш Мягмар болон сурагчдын замбараагүй хичээл, сахилга бат, дэг журамгүй явдлыг дараах байдлаар жигшин шоглож бичжээ.

Тус өгүүлэлд «...Утаа манан татсан модон байшингийн дотор урт вандан, сандалууд уруу өөдөө ойчихсон, учиргүй их үймээн шуугиан болж, ширүүн зодоон эхэлжээ. Багш Мягмар нь харин инээдмийн жүжиг үзэж сонирхон суугаа юм шиг сурагчдынхаа зодооныг харж, баясгалантайгаар

инээмсэглэн талархаж самбар дээр 3-4 үсэг бичсэн, гартаа шинэ үсгийн дүрэм барьчихсан амарлангүй дүрээр зогсож байна. Энэ зохисгүй хичээлийг жигшиж, үзэж харахад үнэхээр эвгүй. Бүлгэмийн багш Мягмараас бүртгэлийг авч үзвэл, дөчөөд сурагч ирэхээс дөнгөж 20 гаруй нь иржээ. Хагас сурагчид нь хэрхсэнийг асуувал, хоршоонд бараа гарсан гэж хоёр өдөр хичээлдээ ирээгүй. Тэд очер дугаар олж зогссон гэнэ»¹⁰ гэх зэргээр багш Мягмарын урагшгүй муу ажиллагаанаас шалтгаалан шинэ үсгийн бүлгэм нь ший жүжиг болж байгааг шүүмжлээд, «...шинэ үсэгт сургахын чухлыг сайн мэдэж, сахилгагүй сурагчдаа сайжруулж өөд нь тат » хэмээн анхааруулжээ.

Мөн «Матар» сэтгүүлийн 1943 оны 6 дахь дугаарт нийтлэгдсэн «Ноуль дүнтэй» хэмээх өгүүлэлд Сүхбаатар аймгийн Уул-Баян сумын бага сургуулийн багш, эвлэлийн гишүүн Лувсанжамцын удирдсан гурван сурагчийн хоёр нь гуравдугаар улирлаар 0 дүнтэй суралцсаныг нэрлээд, Лувсанжамц багшийн урагшгүй, хариуцлагагүйгээс болж сурагчид нь ямар байдалд хүрснийг жишээ баримтаар: «...Бүх сурагчдын хувцас хунар нь муу, хүүхдийн бие нь цухуйсан, дээл нь бүснээс доош эмээлийн ганзага шиг салбарсан байжээ. Зарим хүүхдийн гутал нь урагдаж, түрийгээр гишгэсэн, хөлийх

нь хуруу харагдаж байжээ. ...Халуун усны шалан дээр хуруу хиртэй, байшингийн цонхыг цаасалсан боловч уранхай цоорхой байхад, тэр хэвээр хүүхдүүдийг усанд оруулдаг байв. Өнгөрч байгаа шалгалтуудын дүнг ганц журналаар шалгаж өнгөрүүлжээ»¹¹ гэж шүүмжилсэн байна.

«Матар» сэтгүүл мөн архи дарсанд толгойгоо мэдүүлэн, албан ажил цалгардуулагчдыг шүүмжилдэг байв. Тухайлбал: сэтгүүлийн 1942 оны 5-6 дахь дугаарт нийтлэгдсэн «Түүний амралт ийм байв» хошин шог нийтлэлд ажлын өдрийг цаг харан харан байж дуусгамагц, амралтын өдрийг архинд толгойгоо мэдүүлэн өнгөрөөж, айл амьтны доог тохуу болж байгаа хулгар Доржийг шүүмжилсэн бол¹² 1943 оны 6 дахь дугаарт нийтлэгдсэн «Архитай амиа холбожээ» өгүүлэлд Алтанбулагийн оёдлын артелийн ня-бо Дарам гэгч артелийн тайланг гаргадаггүй, аймгийн хариуцлагатанг загнадаг, клубын жүжигт тоглодоггүй хүүхэн Надмидыг зодох гэж ородсон, хоёр ч удаа донгодуулаад засраагүй, хуулиар эдлэх ял ч эдлээд томоожоогүй, аймгийн эвлэлийн байгууллагаас бүртгэл тооцоо шаардахад, «...ингэж донгосвол би чадахгүй. Эвлэлд дурлахгүй байсан ч яахав. Архи уухгүй байж чадахгүй, би. Үргэлж ууна, яадаг юм...»¹³ гэж агсардаг тухай шоглон бичсэн байх жишээтэй. Өөр нэг жишээ хэлэхэд тус сэтгүүлийн 1943 оны 1 дэх

дугаарт нийтлэгдсэн «"Монополь"-ийн чадал уу?» хэмээх өгүүлэлд худалдааны трестийн харьяа хотын морин тэрэгний ажилчин Ёндонжамц согтуугаар агсан тавьж, талхны газрын мастерыг доромжлон загнаж зодоод, шинэ талхнуудыг хиртэй шуудайнд хийн ачиж яваад, өлсгөлөн нохдын хоол болгож байгааг: «...шилтэй тунгалаг "Монополь"-ийг сэтгэл зүрхэндээ холбож, дурлаж байх зүрхэн дээр 48-ийг нэмээд, гоё хонгор морио гуядаж, урагшаа хойшоо довтолж явтал нь ачсан шуудайтай талхны амсар нь гэдэргээ задарч гудамж тойрон талх өнхөрлөө. Горонготсон ноход гэдэс цадав. Ууж дэмийрэн бусдад халдах чинь тохирох уу? Улсын хөрөнгөөр нохой тэжээх нь зөв үү? ...Ажил хэргээ согтуугаар сольж, ардын хэрэглэгдэхүүнийг шударга бус нийлүүлэгчийг албан удирдлага нь яагаад хардаггүй юм бэ?»¹⁴ гэх зэргээр шоглон шүүмжилж бичсэн байна.

«Матар» сэтгүүлийн нийтлэлийн өөр нэг онцлог сэдэв бол мэргэшсэн хулгайч нар байв. Жишээлбэл: 1943 оны 1 дэх дугаарт нийтлэгдсэн «Та минь техникийн хулгайч танхай Самбууг сонирхмуй» хэмээх өгүүлэлд машин хулгайлдаг Самбуугийн удаа дараагийн үйлдлийг жигшүүлэх үүднээс шүүмжлэн: «...Вандан овогтой Самбуу жолооч машин техникийн хулгайч юм. Эртээр хоршооны фордыг хулгайлж аваад Төв аймгийн

Баянцогт сумын Аргалант хэмээх газар 80 километр яваад, амжихыг больж сандрахдаа эвдэлж хэмхэлж хээр хаяад амь нь тэмцэж бачимдахдаа айлын тэмээ хулгайлж унаад, давирч давхин зугтаасан чинь ахицтай хол явж амжсангүй. Албан хүмүүст баригдан, шүүх таслах газар шийтгэгдэн, 6 сараар таслагдсан боловч засралыг олсонгүй...»¹⁵ гэх зэргээр бичсэн байхад, сэтгүүлийн 1943 оны 5 дахь дугаарт нийтлэгдсэн «Амташсан хулгайч Алтангэрэл»¹⁶ материалд театрын жүжигчин, үйлдвэрчний эвлэлийн гишүүн Алтангэрэл гэгч нь унадаг дугуй хөтлөн, зургийн аппарат зүүж, шляп (бүрх), савхин гутал, цамц зэрэг эд зүйлсийн тун овжин хулгайч болохыг илчлэн шүүмжилсэн байдаг.



Матар» сэтгүүл түүнчлэн муу малчдыг шоглон шүүмжилж байв. Сэтгүүлийн 1943 оны 4 дэх дугаарт нийтлэгдсэн «Адгийн муу малчин»¹⁷ өгүүлэлд Төв аймгийн Батсүмбэр сумын малчин Ядамсүрэн эхнэр Цэрэндуламтайгаа хотоор дүүрэн малтай больё гэж ярилцан, мал бааз дээр очиж, 347 эх малыг худалдаж аваад, малчин хүн шиг хичээж, майлах бүрт нь хашгирч, эхний хэсэг өдөр идэвх сэтгэл ихтэй, эвэг молцогтой хонийг ч илбэн таалж эрхлүүлэн, арай өвөртлөх нь холгүй байсан мөртлөө, Ядамсүрэнгийн ёозгүй бодлого нь гэнэт оволзож, өнгөтэй тарганыг

нь хараад өрлөж алмаар санагдан, өргөн зах дээр худалдвал үнэ хүрмээр бодогдож, ховдог шунал нь цэнэглэж, хохигор толгой нь тонгонож, хоосон хар шүлсээ хов хов залгилж, хумс хуруу нь сунаж, хонины тарганыг шилж, 50-ийг барьж төхөөрөн зах дээр аваачиж худалдаж, үржүүлэх нь байтугай дадлагатай яргачин болсон явдлыг жишээ баримтаар шүүмжилсэн бол 1944 оны 3 дахь дугаарт Ц.Дамдинсүрэнгийн бичиж нийтлүүлсэн «Хоёр муу малчны яриа» нийтлэлд хоёр муу малчин хэрхэн ярилцаж байгааг бичжээ. Тус өгүүлэлд:

«Дулмаа өгүүлрүүн: - Хэдэн үнээ энэ жил Сувайрав. Ганц өрөөсөн хөхтэй үнээ тугаллаад, тугалаа дөнгөж тэжээж байна. Цай сүлэх сүү байхгүй хэнээс гуйдаг билээ. Ханд гуайгаас сүү гуйваас "5 үнээтэй айл 3 үнээтэй айлаас сүү гуйж болох уу?" гэж загнаад сүү өгсөнгүй.

Лувсан өгүүлрүүн: - Надад мөн тийм явдал тохиолдов. Хэдэн адуу байвч ихэнх нь эмнэг болжээ. Ганц номхон морьтой юм сан. Түүний нуруу нь шархтай болоод одоо унаж болохгүй байна. Дорж гуайгаас унаа морь гуйваас "10 морьтой хүн 5 морьтой хүнээс морь гуйж болох уу?" гээд өгсөнгүй. Одоо хазаараа эгэлдэргэлээд хаана очих билээ гэжээ. Дулмаа үнээгээ түшээд хувингаа бариад сүүгүй зогсож байна. Лувсан морио хараад хазаараа бариад

унах унаагүй зогсож байна. Ийм залхуу малчин байваас эднийг үзээд, сэхээ ормоор байна...»¹⁸ хэмээн Лувсан, Дулмаагаар төлөөлүүлэн тааруухан малчдыг нийтэд нь шүүмжилсэн байна.

«Матар» сэтгүүлд дээрх сэдвүүдээс гадна улсын эд хөрөнгийг завшагчид, албан тушаалтануудын хүнд сурталыг шүүмжилсэн нийтлэлүүд ч олонтаа бий. Мөн өөр олон зүйл сэдэв тусгагдаж байсныг ч хэлэх нь зүйтэй.

«Матар» сэтгүүлийн эхний жилүүдийн дугааруудад идэвхтэн бичигчдийн материал зонхилж байсан бол, 1940-өөд оны дунд үеэс тогтмол бүтээлээ нийтлүүлдэг мэргэжлийн төвшний хошин шог зүйл бичигчид бий болжээ.

«Матар» сэтгүүлийн тогтмол нийтлэлчид нь Л.Бадарч, Ц.Цэдэнжав, Ш.Жамбалсүрэн, Д.Даржаа, Ц.Дамдинсүрэн, Б.Ринчен, Х.Пэрлээ, Б.Бааст, Авирмэд нар байв. Эдгээрээс Л.Бадарч, Ц.Цэдэнжав, Ш.Жамбалсүрэн нарын нийтлэлүүд сэтгүүлийн сүүлийн жилүүдийн нийтлэлийн гол байрыг эзэлдэг.

«Матар» сэтгүүл бол Монголын хошин шог нийтлэл хөгжихөд чухал нөлөө үзүүлсэн түүхэн хэвлэл мөн.

Ишлэл

- ¹ "Матар" сэтгүүл. 1942. №1.
- ² "Матар" сэтгүүл. 1942. №1.
- ³ "Матар" сэтгүүл. 1942. №5-6.
- ⁴ "Матар" сэтгүүл. 1943. №3.
- ⁵ "Матар" сэтгүүл. 1943. №3.
- ⁶ "Матар" сэтгүүл. 1942. № 4.
- ⁷ "Матар" сэтгүүл. 1943. № 3.

⁸ "Матар" сэтгүүл. 1942. № 5-6.

⁹ "Матар" сэтгүүл. 1944. №4.

¹⁰ "Матар" сэтгүүл. 1943. №1.

¹¹ "Матар" сэтгүүл. 1943. №6.

¹² "Матар" сэтгүүл. 1942. №5-6.

¹³ "Матар" сэтгүүл. 1943. №6.

¹⁴ "Матар" сэтгүүл. 1943. №1.

¹⁵ "Матар" сэтгүүл. 1943. №1.

¹⁶ "Матар" сэтгүүл. 1943. №5.

¹⁷ "Матар" сэтгүүл. 1943. №4.

¹⁸ "Матар" сэтгүүл. 1944. №3.

Ашигласан бүтээлийн жагсаалт

1. Дэлэг Г. 1965. Монголын тогтмол хэвлэлийн түүхэн тэмдэглэл. УБ.

2. Дэлэг Г. 1971, 1972. Монголын хэвлэл. I, II боть. УБ.

3. Норовсүрэн Л. 2005. Сэтгүүл зүйн бичлэгийн төрөл, зүйл. УБ.

4. Норовсүрэн Л. 2004. Монголын нийтлэл. Тэргүүн дэвтэр. УБ.

5. Норовсүрэн Л. 2000. Монголын сэтгүүл зүйн түүхэн тойм. Тэргүүн боть. УБ.

6. "Матар" сэтгүүл. 1942-1960 оны дугаарууд.

7. "Хүмүүжил жигшил" сэтгүүл. 1935, 1961-1965 оны дугаарууд.

Резюме

В данной статье автор описывает специфику публикаций журнала «Матар» («Крокодил»), который сыграл ключевую роль в развитии и становлении монгольской юмористической и сатирической прессы. Пионером в этой области являлся журнал «Хумуужил жигшил» («Воспитание и презрение»), выходивший в 1935-1942 гг. «Матар», ставший его преемником, выступал как рупор социалистического воспитания и идеолог коммунистического самосознания. Главной тематикой журнала «Матар» являлись такие злободневные недостатки, как халатность, пьянство, лень, потеря стыда, пренебрежительное отношение к труду, к своей обязанности. Носители всевозможных пороков подвергались беспощадной, уничижительной критике на страницах журнала. При этом, журналистами и активистами широко использовались литературные приёмы, в частности, преувеличение.